



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/34/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежер түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhsetsteg.e@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70503020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайр: dornogovi@audit.gov.mn

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ
ДАХЬ ГАЗРЫН ДАРГА П.ТУЛГА

2020-02-14 № 1-6/68
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг албаны дарга П.Тулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-аас 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 11/07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгууллагын эрхэм зорилго нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулахад оршино”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Гадаадын иргэн, харьяатын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Unicus программ хангамж ашигладаг байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 355436.7 мянган төгрөгөөс тооцон 3554.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5179.2 мянган төгрөгөөр тооцсон нь аудитын төлөвлөлтийн үе шатанд 1 хувиар тооцсоныг өөрчлөөгүй холбоотой болно. /шалтгааныг бичих/

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 188594.1 мянган төгрөгөөр буюу 20.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	68610.1	95497.6	26887.5
Үндсэн хөрөнгө	860028.3	1021734.9	161707.6
Нийт хөрөнгө	928638.5	1117232.6	188594.1
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6821.7	6821.7	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	928638.5	1117232.6	161707.6

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь ГИХГ-аас 23746.4 мянган төгрөгийн нормын хувцас, 8853.3 мянган төгрөгийн улсын мэдээллийн маягт, хойд бүсээс 1189.6 мянган төгрөгийн нормын хувцас, 3479.4 мянган төгрөгийн албаны цүнх, Буянт-Ухаа дахь газраас 731.5 мянган төгрөгийн аж ахуйн материал балансаас балансад шилжүүлэн авсан байна. Мөн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 901.7 мянган төгрөгийн бараа, материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 331 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвшөөрлөөр Замын-Үүд сумын ЗДТГ-аас 161500.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 автомашин, 39000.0 мянган төгрөгийн үнэ бүхий орон сууц, 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-1/4445 тоот албан бичгээр хүргүүлсэн зөвшөөрлийн дагуу ГИХГ-аас тус байгууллагад 19383.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус тус шилжүүлэн авсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Гадаадын иргэн, харьяатын газрын тайлант онд улсын төсвөөс 453383.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдснаас гүйцэтгэлээр 446416.3 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	453383.1	446416.3	6966.8	98.5
Нийт дүн	453383.1	446416.3	6966.8	98.5

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 453383.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 453383.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 446416.3 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг төлөвлөсний дагуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Тус дансанд төрийн өмчийн байрыг түрээсэлсний төлбөр болох 37933.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Орлогын 30 хувь болох 11379.9 мянган төгрөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт /ТӨБЗГ-ын 2019 оны 102 дугаар тогтоолын 2 дугаар хэсэг/, 70 хувь болох 26553.2 мянган төгрөгийг Гадаадын иргэн харьяатын газрын дансанд тус тус шилжүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1520.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1520.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Гадаадын иргэн, харьяатын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 17 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 13965 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1270.3 сая төгрөгийн албан шаардлага тогтоосноос бүрэн барагдуулсан байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага 2019 оны 5-р сард ажил гүйцэтгэх 2 гэрээ байгуулсан байна. Гэрээний хэрэгжилтийг шалгахад тухайн ажил үйлчилгээг гэрээнд заасан нөхцөл шаардлагын дагуу хүлээж авсан эсэх нь тодорхойгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй, хүлээж авсан акт байхгүй байна. Үүнийг санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үзэхэд гэрээг дүгнээгүй, гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээж авсан эсэх, шаардсан нөхцөл шаардлагыг хангасан эсэх нь тодорхойгүй байна.

1.2. Эрсдэл:

Чанаргүй, нөхцөл шаардлага хангаагүй бараа, ажил үйлчилгээг худалдан авах эрсдлийн бий болгож байна.

1.3. Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээнд заасан нөхцөл шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж, гэрээг тухай бүр дүгнэж, санхүүжилтийг олгож ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,610,126.52	95,497,606.95
35	БАРАА МАТЕРИАЛ	68,610,126.52	95,497,606.95
35400	Хангамжийн материал	68,610,126.52	95,497,606.95
35410	Бичиг хэргийн материал	6,141,804.00	9,729,729.00
35420	Аж ахуйн материал	28,216,088.45	28,082,576.88
35430	Сэлбэг хэрэгсэл	213,300.00	268,500.00
35440	Түлш,шатах тослох материал	634,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	1,415,700.00	1,415,700.00
35470	Бусад хангамжийн материал	31,989,234.07	56,001,101.07
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	860,028,341.38	1,021,734,956.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	860,028,341.38	1,021,734,956.17
39200	Биет хөрөнгө	851,650,841.38	1,013,852,456.17
39201	Барилга,байгууламж,орон сууц	781,245,814.44	820,245,814.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	(18,404,309.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	181,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,000,000.08)	(20,062,500.09)
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	123,913,831.88	143,297,444.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,080,495.27)	(104,752,020.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,544,451.33	46,544,451.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,972,760.92)	(34,516,424.16)
39300	Биет бус хөрөнгө	8,377,500.00	7,882,500.00
39301	Програм хангамж	1,980,000.00	1,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(82,500.00)	(577,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,480,000.00	6,480,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	928,638,467.90	1,117,232,563.12
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	928,638,467.90	1,117,232,563.12
51	Засгийн газрын хувь оролцоо	6,821,741.82	6,821,741.82
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,821,741.82	6,821,741.82
51200	Хуримтлагдсан үр дүн	770,457,120.58	959,051,215.80
51210	Өмнөх үеийн үр дүн	770,457,120.58	770,457,120.58
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	188,594,095.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	151,359,605.50	151,359,605.50
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	928,638,467.90	1,117,232,563.12

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	467,587,835.05	706,509,586.43
12	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,000,135.05	253,126,486.43
120	<u>Нийтлэг татварын бус орлого	40,000,135.05	253,126,486.43
120004	<u>Төсөв байгууллагын өөрийн орлого	40,000,135.05	253,126,486.43
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,000,135.05	253,126,486.43
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,587,700.00	453,383,100.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	427,587,700.00	453,383,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	427,587,700.00	453,383,100.00
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	472,939,488.73	517,915,491.21
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	472,939,488.73	517,915,491.21
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,743,295.89	509,808,706.79
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	279,062,520.86	313,773,095.83
210101	Үндсэн цалин	174,272,236.07	191,871,795.83
210102	Нэмэгдэл	74,151,300.00	84,941,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,638,984.79	36,960,000.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,665,304.12	39,206,350.96
210201	Тэтгэврийн даатгал	21,921,000.00	26,660,533.54
210202	Тэтгэмжийн даатгал	3,140,100.00	3,043,327.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,893,248.67	2,602,407.45
210204	Ажилгүйдлийн даатгал	628,000.00	627,174.09
210205	Эрүүл мэндийн даатгал	6,082,955.45	6,272,908.62
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,159,626.20	30,560,734.45
210301	Гэрэл, цахилгаан	8,475,817.90	7,453,138.45
210302	Түлш, халаалт	19,554,808.30	19,040,827.00
210303	Цэвэр, бохир ус	7,129,000.00	4,066,769.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	41,337,103.64	40,862,885.74
210401	Бичиг хэрэг	3,911,350.00	5,025,975.00
210402	Тээвэр, шатахуун	22,234,700.00	25,668,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,310,205.98	4,186,838.34
210404	Ном, хэвлэл	155,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,507,530.00	4,680,402.40
210408	Бараа материал акталсны зардал	8,218,317.66	901,670.00
2105	<u>Нормативт зардал	3,320,663.60	4,819,334.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,320,663.60	4,819,334.60
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	8,803,700.00	7,487,800.00
210604	Урсгал засвар	8,803,700.00	7,487,800.00
2107	<u>Томилолт, зочны зардал	3,812,500.00	2,267,310.00
210702	Дотоод албан томилолт	3,812,500.00	2,267,310.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,703,136.00	6,550,317.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469,900.00	310,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,050.00	199,986.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	67,800.00
210807	Газрын төлбөр	0.00	44,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,941,186.00	5,603,731.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	46,878,741.47	64,280,878.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,660,300.00	4,845,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,469,920.00	3,450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,748,521.47	55,985,578.21
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,196,192.84	8,106,784.42
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг	2,999,600.00	1,140,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,999,600.00	1,140,000.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,196,592.84	6,966,784.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,196,592.84	6,966,784.42
III	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-5,351,653.68	188,594,095.22
VI	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-5,351,653.68	188,594,095.22

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<i>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</i>	427,587,700.00	453,383,100.00
13	<i>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</i>	427,587,700.00	453,383,100.00
1310	<i>Улсын төвлөрсөн төсвөөс</i>	427,587,700.00	453,383,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	427,587,700.00	453,383,100.00
II	<i>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</i>	427,587,700.00	453,383,100.00
21	<i>УРСГАЛ ЗАРДАЛ</i>	427,587,700.00	453,383,100.00
210	<i>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</i>	411,391,507.16	445,276,315.58
2101	<i>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</i>	279,062,520.86	313,773,095.83
210101	Үндсэн цалин	174,272,236.07	191,871,795.83
210102	Нэмэгдэл	74,151,300.00	84,941,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,638,984.79	36,960,000.00
2102	<i>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</i>	33,665,304.12	39,206,350.96
210201	Тэтгэврийн даатгал	21,921,000.00	26,660,533.54
210202	Тэтгэмжийн даатгал	3,140,100.00	3,043,327.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,893,248.67	2,602,407.45
210204	Ажилгүйдлийн даатгал	628,000.00	627,174.09
210205	Эрүүл мэндийн даатгал	6,082,955.45	6,272,908.62
2103	<i>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</i>	35,159,626.20	30,560,734.45
210301	Гэрэл, цахилгаан	8,475,817.90	7,453,138.45
210302	Түлш, халаалт	19,554,808.30	19,040,827.00
210303	Цэвэр, бохир ус	7,129,000.00	4,066,769.00
2104	<i>Хангамж, бараа материалын зардал</i>	32,183,105.98	35,188,638.34
210401	Бичиг хэрэг	4,700,000.00	4,700,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,488,700.00	21,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,295,205.98	4,186,838.34
210404	Ном, хэвлэл	210,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,489,200.00	4,401,800.00
2106	<i>Эд хогшил, урсгал засварын зардал</i>	10,416,500.00	7,787,800.00
210604	Урсгал засвар	10,416,500.00	7,787,800.00
2107	<i>Томиллолт, зочны зардал</i>	3,812,500.00	2,267,310.00
210702	Дотоод албан томиллолт	3,812,500.00	2,267,310.00
2108	<i>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</i>	6,061,950.00	7,506,086.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,469,900.00	3,370,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,050.00	199,986.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	67,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	3,000,000.00
210807	Газрын төлбөр	0.00	44,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,000.00	500,000.00
2109	<i>Бараа үйлчилгээний бусад зардал</i>	11,030,000.00	8,986,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,320,000.00	5,536,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,710,000.00	3,450,000.00
213	<i>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</i>	16,196,192.84	8,106,784.42
2132	<i>Бусад урсгал шилжүүлэг</i>	2,999,600.00	1,140,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,999,600.00	1,140,000.00
2133	<i>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</i>	13,196,592.84	6,966,784.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,196,592.84	6,966,784.42
VIII	<i>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</i>	0.00	0.00
IX	<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	0.00	0.00
X	<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	0.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	0.00	775,808,774.26	775,808,774.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,821,741.82	0.00	0.00	6,821,741.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	151,359,605.50	0.00	151,359,605.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-5,351,653.68	-5,351,653.68
2018 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	6,821,741.82	151,359,605.50	770,457,120.58	928,638,467.90
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	188,594,095.22	188,594,095.22
2019 оын 12 сарын 31-р үлдэгдэл	6,821,741.82	151,359,605.50	959,051,215.80	1,117,232,563.12

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	<i>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	453,383,100.00	446,416,315.58	6,966,784.42	98.46
II	<i>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	453,383,100.00	446,416,315.58	6,966,784.42	98.46
21	<i>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	451,383,100.00	445,276,315.58	6,106,784.42	98.65
210	<i>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,979,600.00	92,296,868.79	4,682,731.21	95.17
2101	<i>Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	313,803,100.00	313,773,095.83	30,004.17	99.99
210101	Үндсэн цалин	191,901,800.00	191,871,795.83	30,004.17	99.98
210102	Нэмэгдэл цалин	84,941,300.00	84,941,300.00	0.00	100.00
210103	Унаа хоолны нэмэгдэл	36,960,000.00	36,960,000.00	0.00	100.00
2102	<i>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,600,400.00	39,206,350.96	1,394,049.04	96.57
210201	Тэтгэврийн даатгал	27,608,300.00	26,660,533.54	947,766.46	96.57
210202	Тэтгэмжийн даатгал	3,248,000.00	3,043,327.26	204,672.74	93.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,598,400.00	2,602,407.45	-4,007.45	100.15
210204	Ажилгүйдлийн даатгал	649,600.00	627,174.09	22,425.91	96.55
210205	Эрүүл мэндийн даатгал	6,496,100.00	6,272,908.62	223,191.38	96.56
2103	<i>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,277,300.00	30,560,734.45	2,716,565.55	91.84
210301	Гэрэл, цахилгаан	8,186,100.00	7,453,138.45	732,961.55	91.05
210302	Түлш, халаалт	19,461,400.00	19,040,827.00	420,573.00	97.84
210303	Цэвэр, бохир ус	5,629,000.00	4,066,769.00	1,562,231.00	72.25
210304	Байрны түрээс	800.00	0.00	800.00	0.00
2104	<i>Хангамж, бараа материалын зардал	35,950,200.00	35,188,638.34	761,561.66	97.88
210401	Бичиг хэрэг	4,700,000.00	4,700,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	21,500,000.00	21,500,000.00	0.00	100.00
210403	Шуудан,холбоо, интернетийн төлбөр	4,248,400.00	4,186,838.34	61,561.66	98.55
210404	Ном, хэвлэл	400,000.00	400,000.00	0.00	100.00
210406	БҮТЭЗүйлс	5,101,800.00	4,401,800.00	700,000.00	86.28
2106	<i>Эд хогшил, урсгал засварын зардал	7,787,800.00	7,787,800.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	7,787,800.00	7,787,800.00	0.00	100.00
2107	<i>Томилолт, зочны зардал	2,859,000.00	2,267,310.00	591,690.00	79.30
210702	Дотоод албан томилолт	2,859,000.00	2,267,310.00	591,690.00	79.30
2108	<i>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,535,300.00	7,506,086.00	29,214.00	99.61
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,399,500.00	3,370,300.00	29,200.00	99.14
210802	Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	199,986.00	14.00	99.99
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	67,800.00	67,800.00	0.00	100.00
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	44,000.00	44,000.00	0.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	500,000.00	500,000.00	0.00	100.00
2109	<i>Бараа үйлчилгээний бусад зардал	9,570,000.00	8,986,300.00	583,700.00	93.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,120,000.00	5,536,300.00	583,700.00	90.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,450,000.00	3,450,000.00	0.00	100.00
213	<i>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,140,000.00	860,000.00	57.00
2132	<i>Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,140,000.00	860,000.00	57.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,урамшуулал	2,000,000.00	1,140,000.00	860,000.00	57.00
1	<i>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	453,383,100.00	446,416,315.58	6,966,784.42	98.46
13	<i>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	453,383,100.00	446,416,315.58	6,966,784.42	98.46
131001	Улсын төсвөөс санхүүжих	453,383,100.00	446,416,315.58	6,966,784.42	98.46